



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

“Сэлэнгэ Эстимэйт” ХХК-д даатгалын  
хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.2, 11.1, 11.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Сэлэнгэ Эстимэйт” ХХК-д даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.
2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Сэлэнгэ Эстимэйт” ХХК /Г.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

00007\*